



"МЕРЕКС" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 02-р сарын 13-ний өдөр

№ 1/2301

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилахгүй тухай

Компанийн тухай хуулийн 46,5 дахь заалтыг үндэслэн, 2022 онд ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн тухай хуулийн 47.1.2 дахь заалтад заасан нөхцөл хангадаагүй тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар ТОГТООСУГАЙ.
2. Компанийн тухай хуулийн 46.6 дахь заалтад заасны дагуу ногдол ашиг хуваарилахгүй байх үндэслэлийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнахыг ТУЗ-ийн дарга Г.Бямбабаяр-т ҮҮРЭГ БОЛГОСУГАЙ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.БЯМБАБАЯР



"МЕРЕКС" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 02-р сарын 13-ний өдөр

№ 1/2023

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60, 62 64, 65 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12-р сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. "Мерекс" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 03 сарын 27-ны өдрийн 11:00 цагт Барилга Архитектур Корпорацийн байр 4 давхар 419 тоотод ХУРАДУУЛСУГАЙ.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр ОРУУЛСУГАЙ.
 - а. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах Бүртгэлийн өдрийг 2023 оны 03 сарын 06-ны өдрөөр ТОГТООСУГАЙ.
4. Компанийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2023 оны 02 сарын 17 өдөр, өдөр тутмын хэвлэлээр мэдээлэх, энэ мэдээллийг дээрх хэлбэр шаардлагын дагуу анх мэдээлсэн өдрөөс 15 хоногийн дараа буюу 2023 оны 03 сарын 06 өдөр дахин мэдээлэхийг ТУЗ-ийн нарийн бичигт ДААЛГАСУГАЙ.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлаар хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн санал авах "Саналын хуудас"-ын агуулыг Хавсралт №1-ээр БАТАЛСУГАЙ.
6. Хувьцаа эзэмшигчээс "Саналын хуудас"-ыг харъяалагдах брокер, дилерийн компаниар дамжуулан хүлээн авах сүүлийн өдрийг 2023 оны 03 сарын 27 өдөр байхаар ТОГТООСУГАЙ.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг удирдах хурлын даргаар Г.Бямбабаяр, тооллогын комисст "Мерекс" ХК-ийн Менежер А.Билгүүнийг даргаар, нарийн бичиг Д.Уянга нарыг гишүүдээр тус тус ТОМИЛСУГАЙ.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Г.БЯМБАБАЯР